



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 1/170

Шивээговь сум


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн “Сумын 2023 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын 2023 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Боловсролын байгууллагын шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах” ажилд 46,404,000 (дөчин зургаан сая дөрвөн зуун дөрвөн мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.“Боловсролын байгууллагын шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах” ажилд зарцуулагдах 46,404,000 (дөчин зургаан сая дөрвөн зуун дөрвөн мянга) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас зохих журмын дагуу анхан шатны баримт бичгийн бүрдлийг ханган зарцуулахыг нягтлан бодогч (Л.Цэнд-Аюуш)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Ч СУГАРМАА

